



БАТЛАВ:

ЭРҮҮЛ МЭНДИЙН ЯАМНЫ ДЭРГЭДЭХ  
УЛАМЖЛАЛТ АНАГААХ УХААН СУДЛАЛЫН  
МЭРГЭЖЛИЙН САЛБАР ЗӨВЛӨЛИЙН  
ДАРГА



САЛБАР  
ЗӨВЛӨЛ  
23  
УХА0578  
Д.ЦЭНД-АЮУШ

УЛАМЖЛАЛТ АНАГААХ УХААНЫ ХҮНИЙ ИХ ЭМЧИЙН  
“МОНГОЛЫН УЛАМЖЛАЛТ АНАГААХ УХААНЫ  
ХҮҮХЭД СУДЛАЛ”-ЫН  
ҮНДСЭН МЭРГЭШЛИЙН СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР

Индекс: S(r) 091706

Хугацаа: 2 жил

УЛААНБААТАР ХОТ  
2022 он

## **БОЛОВСРУУЛСАН АЖЛЫН ХЭСЭГ:**

### **Ахлах:**

Д.Нацагдорж

Манба Дацан Монголын уламжлалт эмнэлэг сургалтын төвийн захирал, Монгол улсын гавьяат эмч, профессор

### **Гишүүд:**

Р. Молор

“Тэжээхүй ухаан” ТББ-ын тэргүүн, “Сумади” эмнэлгийн захирал, клиникийн профессор

Н. Эрдэнэжаргал

Оточ манрамба их сургуулийн Уламжлалт анагаах ухааны тэнхимийн багш, Анагаах ухааны магистр

Н. Наранцэцэг

Оточ манрамба их сургуулийн Уламжлалт анагаах ухааны тэнхимийн багш, Бизнесийн удирдлагын магистр

### **Хянасан:**

П.Эрхэмбаяр

Эрүүл мэндийн яамны Төрийн захиргааны удирдлагын газрын дарга, Нийгмийн эрүүл мэндийн магистр

М.Оюунчимэг

Эрүүл мэндийн яамны Эмнэлгийн тусlamж, үйлчилгээний газрын Уламжлалт анагаах ухааны хэлтсийн Уламжлалт анагаах ухааны тусlamж үйлчилгээ хариуцсан ахлах шинжээч

Эмнэлгийн мэргэжилтний хөгжлийн зөвлөлийн  
2022 оны 09 дүгээр сарын 23-ны өдрийн  
29 дүгээр тогтооспор зөвшөөрөв.

**УЛАМЖЛАЛТ АНАГААХ УХААНЫ ХҮНИЙ ИХ ЭМЧИЙН  
“МОНГОЛЫН УЛАМЖЛАЛТ АНАГААХ УХААНЫ ХҮҮХЭД СУДЛАЛ”  
ҮНДСЭН МЭРГЭШЛИЙН СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР**

**НЭГ. ҮНДЭСЛЭЛ**

Монголын уламжлалт анагаах ухаан нь Монгол үндэстний баялаг өвийн нэг бөгөөд түүхэн урт хугацаанд түүний мөн чанар, онол, арга зүй, эмийн түүхий эд, эмийн найрлага, оношилгоо, эмчилгээний арга барилыг олон талаар судалж, баяжуулан хөгжүүлж, ард түмнийхээ эрүүл мэндийг хамгаалж, өвчин эмгэгтэй тэмцэж ирсэн биеz даасан анагаах ухаан буюу шинжлэх ухааны нэгэн томоохон салбар юм.

Монгол Улс Эрүүл мэндийн тухай хуульдаа “Хүмүүнлэг, энэрэнгүй ёс, шинжлэх ухааны мэдлэг, ололт, нотолгоо, орчин үеийн болон уламжлалт анагаах ухааны дэвшилтээт аргад тулгуурлан хүн амд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг үзүүлэх” гэж хуульчилсан төдийгүй эрүүл мэндийн тусламж, үйлчилгээд уламжлалт анагаах ухааныг хос морь болгон зэрэгцүүлэн хөгжүүлэхээр бодлого, эрхзүйн орчинд тусган “Алсын хараа-2050” урт хугацааны хөгжлийн бодлогод “Монголын уламжлалт анагаах ухааныг орчин үеийн анагаах ухаантай хослуулан хөгжүүлж экспортод гарах гарцыг дэмжин “брэнд” болгох” зорилтыг тусгаад байна.

Түүнчлэн уламжлалт анагаах ухааны тусламж, үйлчилгээг дагнан үзүүлэх Нэгдсэн эмнэлгийг хуулиар зөвшөөрч, уламжлалт анагаах ухаан үндсэн болон төрөлжсөн мэргэшлийн тусламж, үйлчилгээ үзүүлэх стандарт батлагдаж, Эрүүл мэндийн сайдын 2021 оны A/445 дугаар “Төгсөлтийн дараах үндсэн ба төрөлжсөн мэргэшлийн сургалтын чиглэл, индекс шинэчлэн батлах тухай” тушаалаар уламжлалт анагаах ухааны үндсэн мэргэшлийн 6 сургалтын чиглэл, индекс (дотор, мэдрэл, хүүхэд, эмэгтэйчүүд, засал, эм) нэмэгдэж шинээр батлагдлаа.

Ийнхүү сургалтын эрхзүйн орчин шинэчлэгдсэнтэй холбогдуулан Эрүүл мэндийн сайдын 2021 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн A/445 дугаар тушаалаар батлагдсан “Уламжлалт анагаах ухааны хүүхэд судлал”-ын үндсэн мэргэшлийн сургалтын чиглэл, индексийн дагуу тус хөтөлбөрийг шинээр боловсруулав.

Энэхүү хөтөлбөр нь анагаах ухааны чиглэлээр их, дээд сургуулийг бакалаврын зэрэгтэй уламжлалт анагаах ухааны хүний их эмчийн мэргэжлээр төгссөн, уламжлалт анагаах ухааны хүүхэд судлал үндсэн мэргэшлийн сургалтад хамрагдаж буй резидент эмч нарт зориулагдана.

## ХОЁР. ЭРХЭМ ЗОРИЛГО

Уламжлалт анагаах ухааны онолоор хүүхдийн өвчин эмгэгийг оношлох, эмчлэх, өвчин үгүй оршиход эрүүл мэндийн зөвлөгөө өгөх чадамж бүхий уламжлалт анагаах ухааны хүүхэд судлалын мэргэшсэн эмч бэлтгэхэд оршино.

### ГУРАВ. АЛСЫН ХАРАА

**Монголын уламжлалт анагаах ухааны хүүхэд судлалын сургалтын хөтөлбөрөөр бэлтгэх эмчийн дүр зураг:**

- Хүүхдийг өвчинөөс урьдчилан сэргийлэх арга, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх үүрэг, хариуцлагаа бүрэн ойлгосон;
- Уламжлалт анагаах ухааны онолоор хүүхдийн өвчний оношилгоо, эмчилгээ хийхэд шаардагдах онолын мэдлэг, ур чадварыг эзэмшсэн;
- Үйлчлүүлэгчийг энэрэх, асрах, тэгш сэтгэлээр хандах, эмчийн ёс зүйг чандлан сахидаг, багаар ажиллах чадвартай, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг чанар аюулгүй байдлыг хангаж үр дүнтэй үзүүлж чаддаг уламжлалт анагаах ухааны хүүхдийн эмч байна.

### ДӨРӨВ. СУРГАЛТЫН ЗОРИЛТ

Алсын харааг хэрэгжүүлэхэд чиглэсэн дараах цогц чадамжтай байна:

1. Мэргэжлийн байх (*Professional*)
2. Тасралтгүй суралцагч байх (*Continuous Learner*)
3. Харилцагч байх (*Communicator*)
4. Хамтрагч байх (*Collaborator*)
5. Хүн амын эрүүл мэндийн зөвлөгч (*Community Health Advocate*)
6. Зохион байгуулагч, манлайлагч (*Leader*)

Энэхүү цогц чадамж нь уламжлалт анагаах ухааны хүүхдийн эмчийг төлөвшүүлэхэд чиглэсэн мэдлэг, чадвар, хандлагын тухай ойлголт юм. Үүнд:

#### 1. Мэргэжлийн байх (*Professional*)

- Бүх шатлалын эрүүл мэндийн байгууллагад уламжлалт анагаах ухааны хүүхдийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг чанартай, хүртээмжтэй аюулгүй үзүүлэх чадвартай хүүхдийн өвчний шалтгаан, нөхцөл, хувирах ёс, ялган оношилгоо, шинж тэмдэг (*signs and symptoms*), эмчлэх арга ухаан, гардан үйлдлийг бүрэн эзэмшиж, мэргэшсэн байх;
- Үйлчлүүлэгчээс асуумж авах, үзэх, хүрэлцэх аргаар шинжлэх, хүүхдийн нас, хүйс, цаг улирал, сэтгэл зүй, нийгмийн нөхцөл байдлыг үнэлж, уламжлалт анагаах ухааны онолоор оношилгоо, эмчилгээ хийн, хяналтын төлөвлөгөө гаргаж хэрэгжүүлэх чадвартай байх;
- Үйлчлүүлэгчийн хувийн нууцыг хадгалах;
- Үйлчлүүлэгчийн өвдөлт, сэтгэл зовнилд анхаарал хандуулах;

- Эрүүл мэндийн байгууллагын дүрэм, журам, стандарт, эмнэлзүйн заавар, бүртгэл мэдээлэл, тайланг зохих журмын дагуу цаг хугацаанд нь хөтлөх;
- Эмнэлгийн анхны болон амилуулах суурь тусламж үзүүлэх мэдлэг, чадвар эзэмшсэн байх.
- Уламжлалт анагаах ухааны онолоор өвчнөөс урьдчилан сэргийлэх, өвчингүй орших ухаан, зөв зан үйлийг таниулан ойлгуулах мэдлэг чадвартай байх;
- Жирэмсэн эхчүүдэд уламжлалт анагаах ухааны онолын үүднээс хийн хувиралтай уялдсан хяналт, зөвлөгөө, хүүхдийн нас, тухайн цаг улирал, нийгмийн нөхцөл байдалд нь тохирсон сэтгэл зүй, идээ, унд, явдал мөрийн зөвлөгөө өгөх мэдлэг чадвартай байх;
- Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх явцад эмнэлгийн хүчин чадал хүрэлцэхгүй нөхцөлийг тодорхойлох, дараагийн шатлалын эмнэлэгт шилжүүлэх арга хэмжээг шуурхай авах, анхны тусламж үзүүлэх мэдлэг, чадвартай байх;
- Үйлчлүүлэгч болон түүний гэр бүлийн гишүүн, асран хамгаалагч, төрөл садантай хувь хүний онцлогийг харгалзан хүндэтгэлтэй ёс зүйтэй харилцах.

## **2. Тасралтгүй суралцагч байх (*Continuous Learner*)**

- Мэргэжлийн нэр төрийг өндөрт өргөж, үнэнч шударга, чин сэтгэлээсээ хандаж суралцах;
- Уламжлалт анагаах ухааны онол, дадлага, мэдлэг, ур чадвараа дээшлүүлэхийн тулд суралцах бичиг, эрдэм шинжилгээний нотолгоо, судалгаа, мэргэжлийн судар, эх сурвалжийг судлах, дүн шинжилгээ хийх, бие даан тасралтгүйгээр суралцах, чармайлттай байх;
- Ижил мэргэжлийн эмч наортай багаар ажиллах, мэдлэг туршлагаа хуваалцах, төрөлжсөн мэргэшил эзэмших чин эрмэлзэлтэй болох;
- Хамтран суралцагч эмч, бусад эмнэлгийн мэргэжилтэнд, заах, зөвлөгөө өгөх замаар өөрийн мэдлэг, чадвараа сайжруулах.

## **3. Харилцагч байх (*Communicator*)**

- Үйлчлүүлэгч болон түүний гэр бүлийн гишүүн, асран хамгаалагч, төрөл, садан, эмнэлгийн мэргэжилтэн наортай зүй зохистой үг хэллэг ашиглан хүнлэг, энэрэнгүй, зөв боловсон харилцах, мэргэжлийн харилцаа хандлага, иргэний болон мэргэжлийн ёс зүй, эмчийн тангарагтаа үнэнч байх;
- Үйлчлүүлэгчид эрүүл мэндийн болон эмчилгээ, оношилгооны мэдээлэл өгөхдөө ойлгоход хялбар, энгийн үг хэллэг ашиглан тайлбарлан ойлгуулах;
- Үйлчлүүлэгчийн оношилгоо, эмчилгээний талаар бусад эмнэлгийн мэргэжилтэнтэй зөвлөлдөх, туршлага солилцох, эргэлзээг арилгах;
- Эмч эмнэлгийн мэргэжилтэнтэй харьцахдаа ёс зүйн өндөр боловсролтой байж, харилцан хүндэтгэлтэй хандаж, мэргэжлийн чиглэлээр мэдлэг ур чадвараа дээшлүүлэх;

- Өөрийн гаргасан оношилгоо эмчилгээг шинжлэх ухаан, онолын үндэслэлтэй тайлбарлах мэдлэг чадвартай байх.

#### **4. Хамтрагч байх (*Collaborator*)**

- Эмнэлгийн мэргэжилтэн, эрүүл мэндийн ажилтан нартай мэдлэг, мэдээлэл солилцож, харилцан хүндэтгэн хамтран ажиллах;
- Байгууллага, тасаг, нэгж, хамт олноо удирдан зохион байгуулах, эмнэлзүй, эрдэм шинжилгээний хурал зохион байгуулах чадвартай байх;
- Эмнэлгийн хамт олон, мэргэжлийн нийгэмлэг холбоод, сайн үйлс, нийгэм олон нийтийн ажилд идэвхтэй оролцож, зерэг хандлагатай байх;
- Эмнэлгийн бусад тасгийн эмч, эмнэлгийн мэргэжилтэнтэй мэргэжлийн мэдлэг, мэдээллээ хуваалцах, хамтран ажиллах.

#### **5. Хүн амын эрүүл мэндийн зөвлөгч (*Community Health Advocate*)**

- Хүн амын эрүүл мэндийн зөвлөгч байхын тулд уламжлалт анагаах ухааны онолоор өвчнөөс урьдчилан сэргийлэх, өвчингүй орших ухаан, зөв зан үйлийг таниулан ойлгуулах, сургалт сурталчилгаа явуулах;
- Хүүхдийн нас, өвөрчлөл, тухайн цаг улиралд тохирсон идээ, унд, явдал мөрийн зөв дадлын талаар сургалтын мэдээлэл бүхий сургалтын материал, гарын авлага боловсруулж сурталчилгаа явуулах;
- Үйлчлүүлэгч болон түүний гэр бүлийн гишүүн, асран хамгаалагч, төрөл саданд уламжлалт анагаах ухааны онолын үүднээс нас, өвөрчлөл, ажил амьдралын нөхцөлд тохирсон идээ, унд, явдал мөр, асаргааны зөвлөгөө өгөх мэдлэг чадвартай байх.

#### **6. Зохион байгуулагч, манлайлагч (*Leader*)**

- Уламжлалт анагаах ухааны онолоор хүүхдэд үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг зохицуулах, манлайлан ажиллах үүргээ ухамсарлах;
- Нийгэм олон нийтээс зохион байгуулж буй ажилд идэвх санаачилгатай оролцож, хувь хүний чадварыг хөгжүүлж сурх;
- Эмнэлэг, эрүүл мэндийн төв дэх уламжлалт анагаах ухааны тусламж, үйлчилгээ үзүүлэх багийг манлайлан ажиллах, зөв төлөвшил, зерэг хандлага бий болгох үүргээ ухамсарлах;
- Байгууллагын соёл, үйлчилгээг зөв төлөвшүүлэхэд оролцох, хамт олноо эрүүл мэндийн үйлсэд уриалан дуудаж ажилладаг манлайлагч байх;
- Хүний эрх, үүрэг зохих хууль, дүрэм журам шийдвэрийг дагаж мөрдөх, хүнлэг, энэрэнгүй, эх оронч сэтгэлгээг төлөвшүүлэхэд идэвх санаачилгатай оролцох.

## ТАВ. СУРГАЛТЫН АРГА ЗҮЙ

### 5.1. Сургалтын чиглэл, хугацаа, байршил

- Энэхүү сургалтын үйл ажиллагааг сургалт эрхлэх зөвшөөрөл бүхий байгууллага явуулна.
- Бүх шатлалын болон төрөлжсөн мэргэжлийн эрүүл мэндийн байгууллагатай сургалт эрхлэх сүлжээ үүсгэн хамтран ажиллана.
- Сургалтын нийт хугацаа 2 жил байна. Тойролтын хугацааг үндсэн болон бусад сүлжээ сургалт эрхлэх эмнэлгүүдийн онцлог, хүчин чадалд тохируулан зохицуулна.
- Суралцагч эмчийн өдөр тутмын болон 7 хоногийн үйл ажиллагааны хуваарийг сургалтын үндсэн байгууллагууд боловсруулна.
- Сургалт зохион байгуулагдаж буй эмнэлгийн мэргэжилтний ёс зүй, харилцаа, хандлага, халдвартын сэргийлэлт, хяналт, амилуулах суурь тусламж, эрүүл мэндийн салбарт мөрдөгдөж буй хууль, журам, стандарт, заавар, зөрчлийн тухай хууль, хувь хүний нууцтай холбоотой хууль, эмнэлгийн эрх зүйн чиглэлээр сургалтад заавал хамрагдана.

### 5.2. Зайлшгүй танин мэдэж, суралцах шаардлагатай шинж тэмдэг, суурь мэдлэг, өвчин, гардан үйлдэл:

Сургалтын агуулгын хүрээнд уламжлалт анагаах ухааны хүүхэд судлал үндсэн мэргэшлээр суралцаж байгаа эмч нь сургалтын төгсгөлд эмнэл зүйн талбарт бие даан тусламж, үйлчилгээ үзүүлэх ур чадвар, дадлага эзэмшихийн тулд эмнэл зүйн сургагч багшийн удирдлага дор амбулатори болон хэвтэн эмчлүүлэх тасгийн хүрээнд өвчтөнийг оношлох, эмчлэхдээ дор дурдсан шинж тэмдгээр гардан үйлдлийг гүйцэтгэж, туршлага хуримтлуулан үндсэн мэргэшлийн сургалтад оролцно.

#### 5.2.1 Шинж тэмдэг (*signs and symptoms*) (аль ч тойролтод тохиолдох):

Өвчний түүх, бодит үзлэгт үндэслэн эрэмбэлэн ангилж, ялган оношилгоо хийж, анхан шатны эмчилгээг эхлүүлж чаддаг болох:

1. Уйлах шинж /үргэлжид удаан уйлах, чанга уйлах, шөнө уйлах, үүрээр уйлах, бүрийн цагт уйлах, нарийн сөөнгө дуугаар уйлах, ихсэж багасаж тасалдан зогсох байдалтай уйлах, чанга дуу чимээ тэсвэрлэхгүй уйлах/
2. Өвдөх шинж /алин өвдсөн хэсгээ барих, барьсан хэсэгт дарвал тэсэхгүй өвдөх, үүрийн цагт өвдөх/
3. Шээсний шинж /шээс чавдагших, шээс дахин дахин цувирах, шээсний төгсгөлд гэнэт хаагдах, шээсний дунд махны нитгэл гарах/
4. Амьсгалын шинж /богино амьсгалах, урт амьсгалах, амьсгаадах, цээж хонхолзох, хяхтнаж амьсгалах, хэржигнэх/
5. Нүүрний шинж /нүүр харлах, нүүр шарлах, нүүр тослог болох/
6. Нүдний шинж /нүд шарлах, нүд хөхрөх, нүд улайх, нүд цайх, нүдний харц дээш гөлийх, нүдээ нээхэд бэрх болох, нүд ширгэх, нүд халуун оргих, нүдээ олон анивчих, нүдний булангаараа харах, нүд хавдах, нүдээрээ тэнгэр ширтэх/

7. Хэлний шинж /хэл богиносох, хэл голоороо шарлах, хэл цайрах, хэлээ хөхөж хоосноор зажлах, хэл мурийх/
8. Чихний шинж /чихний судас харлаж бүдүүрэх, чихний ар талд шарлах, чихнээс өгөр цувирах, чих дүлийрэх, чих толгойд наалдах/
9. Хумсны шинж /хумс хурц болох, хумс харлах, хумс уртсах/
- 10.Хүйн шинж /хүй овойх, хүй борлох, хүй хавдах, хүй толь мэт хатуу болох, хүй өгөрлөж хонхойх/
- 11.Эхийн хөхний сүүний шинж / хөхний сүү шарлах, хөхний сүү иsgэлэн болох, хөхний сүүг усанд дусаахад хөөстэй хөвөх, хөхөвтөр живэх, хэсэгчлэн тасрах/
- 12.Дууны өнгө /дууны өнгө нь сул болох, дууны өнгө нь ишигний дуу адил болох/
- 13.Арьсны өнгө /арьсны өнгө хөхрөх, арьсны өнгө шарлах, арьсны өнгө алт адил шарлах, хувхай цайх, 4-н толио шарлах, 4-н толио цагаан гялтгар болох, 4-н толио улаан болох/
- 14.Өтгөний шинж /өтгөн хаагдах, өтгөний хэмжээ нь ихсэх/
- 15.Бөөлжих /цустай бөөлжих, шараар бөөлжих, ууж, хөхсөний дараа бөөлжих, юу идсэнээрээ бөөлжих, хөөс бадган салстай бөөлжих, хоосноор огиулах/
- 16.Суулгах /хөхний сүү адил суулгах, улаан өнгөтэй суулгах, шар өнгөтэй суулгах, ногоон өнгөтэй суулгах, хөхөвтөр өнгөтэй суулгах, утааны шүүс адил суулгах, идсэн идээний өнгөөр суулгах, цайвар, хөөстэй суулгах, дуу ихтэй суулгах, шар мөөгний зутан адил суулгах/
- 17.Ханиах /хий ханиах, цэртэй ханиах, ам нүүрээ хумъж ханиах, олон ханиах, угсрулан ханиах/
- 18.Хавдах /өвчүү хэсэгт хавдах, цээжин бие хавдах, нүд хавдах, уруул хавдах/
- 19.Хатах /ам хатах, хэл хатах, хамрын үүд хатах/
- 20.Хаг тогтох /амд хаг тогтох, хэлэн дээр хаг тогтох, уруулд хаг тогтох, шүдэнд хаг тогтох, буйланд хаг тогтох, хамарт хяруу адил цагаан хаг тогтох/
- 21.Самардах /цээжин биеэ самардах, эхийгээ самардах, газар самардах/
- 22.Эвшээж шинж /эвшээж чадахгүй, их эвшээх/
- 23.Гөвдруү гарах /цагаан гөвдруү гарах, гөвдруү тагнайд гарах/
- 24.Зулай лугших
- 25.Дуршил нь хаагдах
- 26.Инээж тоглохгүй болох
- 27.Их хөлрөх
- 28.Хөхөө хөхөхгүй болох
- 29.Толгой, цээжин бие гадагш гарах, дагз гэдийх
- 30.Өсгийгөөрөө гишгэж чадахгүй болох
- 31.Их сарвалзах, таталт өгөх, чичрэх
- 32.Шилэн хүзүү хөших
- 33.Цээжин бие хөших
- 34.Яраглах
- 35.Зүрх дэлсэх
- 36.Гараа хөхөх
- 37.Гэдэс олгой хоржигнох, дүүрэх. унжих
- 38.Ундууцах

39. Шар үс нь буцах, босох
40. Ундаасах
41. Ам хамраа 2 гараараа дарах
42. Хөл, гараа хумиад тэнийлгэж чадахгүй болох
43. Нударгаа зангидах
44. Давсаг, шээсний сүв эвэршээж өвдөх
45. Толгой хавдах
46. Хоолой хаагдах
47. Шүлс нь ихсэх
48. Нулимс цувирах /нэг нүднээс цувирах/
49. Эхийн хөх, өөрийнхөө хэлийг шүдээрээ зуух
50. Шүдээ хавирах
51. Турах
52. Бөгсний судас хавдах
53. Толгойгоо цохих, дохих
54. Зогьсох
55. Гараараа хошногоо ухах, базах
56. Тагнайгаа таших
57. Цочиж, эмээх
58. Хэвлийн судас харлаж тодрох
59. Ам нь мурийх
60. Үс нь сэгсийх

#### **5.2.2. Зайлшгүй суралцаж, таньж мэдэх шаардлагатай өвчин (тойролт тус бүрээр):**

1. Өвчин тус бүрийг оношилж, эмчлэх, зөвлөгөө өгөх чадвартай болох;
2. Тусламж, үйлчилгээ үзүүлэх явцад эмнэлэг хооронд өвчтөн шилжүүлэх заалтыг мэддэг болох;
3. Эмнэлэг хооронд өвчтөнийг шилжүүлэх үеийн тусламж, үйлчилгээг үзүүлэх аргад суралцах;
4. Үйлчлүүлэгч болон түүний гэр бүлийн гишүүн, асран хамгаалагч, төрөл, садны хүнд өвчнөөс урьдчилан сэргийлэх, өвчнийг эрт үед нь илрүүлэх талаар, зөвлөгөө өгөхөд суралцах.

#### **Хүүхдийн хамт төрсөн өвчин (TMQ00.1-TMQ 00.6)**

1. Хүүхдийн дүлий (TMQ00.1) /Deafness /
2. Хүүхдийн сохор (TMQ00.2) /Blindness/
3. Хүүхдийн хэлгий (TMQ00.3) /Dumbness/
4. Хүүхдийн тахир доголон (TMQ00.4) /Lameness/
5. Хүүхдийн бөгтөр (TMQ00.5) /Hunchback/
6. Хүүхдийн сэтэрхий (TMQ00.6) /Clept lip/

#### **Хүүхдийн бүдүүн өвчин (TMQ01.1-TMQ 01.8)**

7. Өвчүүний өвчин (TMQ01.1) /Sternum disease/
8. Уушгини өвчин (TMQ01.2) /Lung disease/
9. Элэгний өвчин (TMQ01.3) /Liver disease/

- 10.Суулга (TMQ01.4) /Diarhhea/
- 11.Бөөлжих (TMQ01.5) /Vomiting/
- 12.Халдварт өвчин (TMQ01.6) /Contagious disease/
- 13.Хүйн өвчин (TMQ01.7) /Umbilical cord disease/
- 14.Чулуушрах өвчин (TMQ01.8) /Petrification disease/

**Хүүдийн нарийн өвчин (TMQ02.1-TMQ 02.8)**

- 15.Толгой хавдах (TMQ02.1) /Swelling of the head/
- 16.Хоолой хаагдах (TMQ02.2) /Hoarseness/
- 17.Дэлүүний өвчин (TMQ02.3) /Spleen disease/
- 18.Цөсний өвчин (TMQ02.4) /Gallbladder disease/
- 19.Ходоодны өвчин (TMQ02.5) /Stomach disease/
- 20.Олгой өвчин (TMQ02.6) /Colon disease/
- 21.Шороо идсэн өвчин (TMQ02.7) /The disease of dirt ate/
- 22.Сүүний өвчин (TMQ02.8) /Mother's milk disease /

**Хүүхдийн машид нарийн (TMQ03.1-TMQ 03.8)**

- 23.Нүдний өвчин (TMQ03.1) /Eye disease/
- 24.Чихний өвчин (TMQ03.2) /Ear disease/
- 25.Амны өвчин (TMQ03.3) /Mouth disease/
- 26.Булчирхайн өвчин (TMQ03.4) /Glandular disease/
- 27.Амин судлын өвчин (TMQ03.5) /Coronary artery disease/
- 28.Махны өвчин (TMQ03.6) /Disease caused by disappointment/
- 29.Хорхойн өвчин (TMQ03.7) /Parasitic disease/
- 30.Мундас өвчин (TMQ03.8) /Paraproctitis/

**Нялхсын адын өвчин (TMQ04.1-TMQ 04.16) /Disease of Evil spirit/**

- 31.Гэмжэд адын өвчин (TMQ04.1)
- 32.Сага адын өвчин (TMQ04.2)
- 33.Лүг дон адын өвчин (TMQ04.3)
- 34.Чи дон адын өвчин (TMQ04.4)
- 35.Едаг адын өвчин (TMQ04.5)
- 36.Жадон адын өвчин (TMQ04.6)
- 37.Срүлмо адын өвчин (TMQ04.7)
- 38.Данбисрүлмо адын өвчин (TMQ04.8)
- 39.Срүлмолонба адын өвчин (TMQ04.9)
- 40.Шинжай адын өвчин (TMQ04.10)
- 41.Намду адын өвчин (TMQ04.11)
- 42.Намду гэмбо адын өвчин (TMQ04.12)
- 43.Хаан адын өвчин (TMQ04.13)
- 44.Хатан адын өвчин (TMQ04.14)
- 45.Хувилгааны суурь их тэнгэр (TMQ04.15)
- 46.Жадэ адын өвчин (TMQ04.16)

**Зонхилон тохиолдох хүүхдийн өвчин**

- 47.Амьсгалын эрхтэн тогтолцооны түгээмэл тохиолдох өвчин (уушгины хатгаа, бронхит, ларингит, багтраа) (Common respiratory diseases (Pneumonia, Bronchiolitis, Laryngitis, Asthma))

48. Хоол боловсруулах эрхтэн тогтолцооны өвчин (суулгалт, шимэгч хорхой) (Intestinal diseases (Diarrhea, Parasitic diseases))
49. Суурь эмгэг (рахит, цус багадалт, хоол тэжээлийн дутагдал, шүүдэст эмзэгшил) (Basic disorder (Rickets, Anemia, Malnutrition, Diathesis exudation))
50. Нярай үеийн асуудлууд (нярайн эрт үеийн нэн шаардлагатай тусlamж) (Early essential newborn care)
51. Өсөлт, хөгжлийн эмгэг өөрчлөлттэй хүүхдийг танъж илрүүлэх үнэлгээ (Evaluation for growth and developmental disorders of children)
52. Тууралтат өвчин (Skin rash)

#### **Яаралтай тусlamж судлал:**

53. Толгой, хүзүү, нурууны гэмтэл (суурь тусlamж, тээвэрлэлт) (Head, neck and spine injury (initial management and transportation))
54. Түлэгдэл, хөлдөлт (Burn and frost-bite)
55. Амьсгалын замд гадны биетээр бөглөрөх, живэх (Foreign body obstruction, Drowning)
56. Ясны хугарал (Fracture)
57. Тархинд цус харвах (цочмог үеийн) (Stroke (acute phase))
58. Зүрхний дутагдал, зүрхний шигдээс (цочмог үеийн) (Heart failure, Myocardial infarction (acute phase))
59. Шок (Shock)
60. Цочмог хордлого (Poisoning, Intoxication)
61. Могой, шавжид хатгуулах (хачиг) (Shake bite, insect bite (tick bite))
62. Буглаа (Abscess)

#### **5.2.3 Гардан үйлдэл**

1. Судсаар оношлох /чихний судсаар оношлох, бугуйн судсаар оношлох, хурууны судсаар оношлох, чамархайн судсаар оношлох/
2. Шээсээр оношлох
3. Хэлээр оношлох
4. Эхийн сүүгээр оношлох
5. Жирэмсний үеийн бария хийх
6. Бүтэн биеийн зөвлөн бария хийх
7. Хэсэгчилсэн бария хийх (Толгойн бария хийх, нурууны бария хийх, тухайн үе мөчдөд бария хийх, 4-н толион бария хий)
8. Арвайтай бария хийх
9. Халуун тосон бария хийх
10. Цэгэн бария хийх
11. Рашаанд оруулах
12. Ясны шөлөнд оруулах
13. Дэвтээлэг /ороох дэвтээлэг хийх, ууран дэвтээлэг хийх/ хийх
14. Туулгах
15. Хануур засал /зэтрээс цус авах, шивүүр хийх, самнуур хийх/ хийх
16. Төөнө (эсгий төөнө хийх, утаат төөнө хийх, эмт төөнө хийх) хийх
17. Жин (халуун жин тавих, хүйтэн жин тавих) тавих

18. Угаалга хийх
19. Түрхлэг түрхэх
20. Нирухагаар татах
21. Зөөлөн шимт хийх
22. Зөгийн балтай татлага хийх
23. Бумба тавих
24. Шавар тавих
25. Зүү тавих
26. Гаргалга хийх /цагаан гаргалга хийх, улаан гаргалга хийх, иsgэлэн гаргалга хийх, сармисан гаргалга хийх/
27. Усаар шавших
28. Соруул засал хийх
29. Дусаалга /нүдний дусаалга дусаах, чихний дусаалга дусаах /дусаах
30. Утлага хийх
31. Шарлага хийх

#### **Яаралтай тусlamжийн гардан үйлдэл**

32. Сэхээн амьдрнуулалтын хүүдий, маск сонгох, шалгах, хэрэглэх
33. Хиймэл амьсгал хийх ба амьсгалын аппарат хэрэглэж амьсгал удирдах
34. Ларингоскоп ашиглан гуурсан хоолойд интубацийн гуурс байрлуулах, шалгах
35. Зүрхэнд иллэг хийх
36. Дефибрилятор ашиглах
37. Ил далд цус алдалтын үед яаралтай тусlamж үзүүлэх
38. Нүд, чих, хамар хоолойд орсон гаднын биетийг авах
39. Амьтанд хазуулах, могой шавьжанд хатгуулсан хүний шарханд анхны цэгцлэлт хийх
40. Үений мултралыг оруулах, ясны хугарлын үед боолт хийх

#### **ЗУРГАА. СУРГАЛТЫН АГУУЛГА**

Сургалт нийт 88 долоо хоног үргэлжлэх ба эхний жил 44 тойролт, хоёрдох жил 44 тойролт нийт 88 тойролтуудыг хийж гүйцэтгэсэн байна.

#### **Тойролтын хуваарь**

№	Тойролтын нэр	Хугацаа /7 хоног/
<b>Эхний жилд: 44 долоо хоног 44 тойролт</b>		
1	Эмнэлгийн эрх зүй	1
2	Харилцааны ур чадвар	
3	Халдвартын сэргийлэлт, хяналт	2
4	Амилуулах суурь тусlamж	2
5	Уламжлалт анагаах ухааны онол, өвчнөөс урьдчилан сэргийлэх арга зүй	8
6	Хүний биетийн бүтэц зүй	3

7	Хүүхдийн оношилгоо		4
8	Хүүхдийн өвчин	Бүдүүн өвчин (TMQ01.1-TMQ 01.8) Нарийн өвчин (TMQ02.1-TMQ 02.8) Машид нарийн өвчин (TMQ03.1-TMQ 03.8)	24
<b>Хоёрдох жилд: 44 долоо хоног 44 тойролт</b>			
1	Яаралтай тусламж		10
2	Хүүхэд судлал		10
3	Нялхсын хамт төрсөн өвчин (TMQ00.1-TMQ 00.6)		10
4	Нялхсын адын өвчин (TMQ04.1-TMQ 04.16)		10
5	Эмнэлгийн зурхай, тарни, гүрэм засал		4

### Тойролтын агуулга

**Нэгдүгээр тойролт: Танилцуулга болон уламжлалт анагаах ухааны онол, өвчнөөс урьдчилан сэргийлэх**

- Эмнэлгийн мэргэжилтний ёс зүй, харилцаа, хандлага
- Эрүүл мэндийн салбарт мөрдөгдөж буй хууль, журам, стандарт, заавар
- Зөрчлийн тухай хууль
- Хувь хүний нууцтай холбоотой хууль
- Халдварын сэргийлэлт, хяналт
- Амилуулах суурь тусламж
- Харилцааны ур чадвар
- Уламжлалт анагаах ухааны үндсэн онол
- Уламжлалт анагаах ухааны эрүүл биеийн үйл зүй
- Уламжлалт анагаах ухааны эмгэг үйл зүй
- Уламжлалт анагаах ухааны оношилгоо
- Уламжлалт анагаах ухааны эмчилгээний зарчим
- Уламжлалт анагаах ухааны өвчнөөс урьдчилан сэргийлэх арга зүй

**Хоёрдугаар тойролт: Хүний биеийн бүтэц зүй, хүүхдийн оношилгоо**

- Бүтэх бие
- Тогтох судас
- Ураг бүрэлдэх явцын онцлог
- Жирэмсний хяналт-төрөлт
- Хүүхдийн өвчнийг чихний судсаар оношлох
- Хүүхдийн өвчнийг хурууны судсаар оношлох
- Хүүхдийн өвчнийг хэлээр оношлох
- Хүүхдийн өвчнийг шээсээр оношлох
- Хүүхдийн өвчнийг эхийн сүүгээр оношлох
- Лабораторийн шинжилгээ
- Зүрхний цахилгаан бичлэг
- Хэт авиан оношилгоо (ЭХО)
- Гэрлийн шинжилгээ (Рентген)

**Гуравдугаар тойролт: Хүүхдийн өвчин**

- Өвчүүний өвчин (TMQ01.1)

- Уушгини өвчин (TMQ01.2)
- Элэгний өвчин (TMQ01.3)
- Суулга (TMQ01.4)
- Бөөлжих (TMQ01.5)
- Халдварт өвчин (TMQ01.6)
- Хүйн өвчин (TMQ01.7)
- Чулуушрах өвчин (TMQ01.8)
- Толгой хавдах (TMQ02.1)
- Хоолой хаагдах (TMQ02.2)
- Дэлүүний өвчин (TMQ02.3)
- Цөсний өвчин (TMQ02.4)
- Ходоодны өвчин (TMQ02.5)
- Олгой өвчин (TMQ02.6)
- Шороо идсэн өвчин (TMQ02.7)
- Сүүний өвчин (TMQ02.8)
- Нүдний өвчин (TMQ03.1)
- Чихний өвчин (TMQ03.2)
- Амны өвчин (TMQ03.3)
- Булчирхайн өвчин (TMQ03.4)
- Амин судлын өвчин (TMQ03.5)
- Махны өвчин (TMQ03.6)
- Хорхойн өвчин (TMQ03.7)
- Мундас өвчин (TMQ03.8)

#### **Дөрөвдүгээр тойролт: Зонхилон тохиолдох хүүхдийн өвчин**

- Амьсгалын эрхтэн тогтолцооны түгээмэл тохиолдох өвчин (уушгини хатгаа, бронхит, ларингит, багтраа) (Common respiratory diseases (Pneumonia, Bronchiolitis, Laryngitis, Asthma))
- Хоол боловсруулах эрхтэн тогтолцооны өвчин (суулгалт, шимэгч хорхой) (Intestinal diseases (Diarrhea, Parasitic diseases))
- Суурь эмгэг (ракит, цус багадалт, хоол тэжээлийн дутагдал, шүүдэст эмзэгшил) (Basic disorder (Rickets, Anemia, Malnutrition, Diathesis exudation))
- Нярай үеийн асуудлууд (нярайн эрт үеийн нэн шаардлагатай тусламж) (Early essential newborn care)
- Өсөлт, хөгжлийн эмгэг өөрчлөлттэй хүүхдийг танъж илрүүлэх үнэлгээ (Evaluation for growth and developmental disorders of children)
- Тууралтат өвчин (Skin rash)

#### **Тавдугаар тойролт: Нялхсын хамт төрсөн өвчин**

- Хүүхдийн Хүүхдийн дүлий (TMQ00.1)
- Хүүхдийн сохор (TMQ00.2)
- Хүүхдийн хэлгий (TMQ00.3)
- Хүүхдийн тахир доголон (TMQ00.4)
- Хүүхдийн бөгтөр (TMQ00.5)
- Хүүхдийн сэтэрхий (TMQ00.6)

#### **Зургаадугаар тойролт: Нялхсын адын өвчин**

- Хүүхдийн Гэмжэд адын өвчин (TMQ04.1)
- Сага адын өвчин (TMQ04.2)

- Лүг дон адын өвчин (TMQ04.3)
- Чи дон адын өвчин (TMQ04.4)
- Едаг адын өвчин (TMQ04.5)
- Жадон адын өвчин (TMQ04.6)
- Срүлмо адын өвчин (TMQ04.7)
- Данбисрүлмо адын өвчин (TMQ04.8)
- Срүлмөлонба адын өвчин (TMQ 04.9)
- Шинжай адын өвчин (TMQ04.10)
- Намду адын өвчин (TMQ04.11)
- Намду гэмбо адын өвчин (TMQ 04.12)
- Хаан адын өвчин (TMQ04.13)
- Хатан адын өвчин (TMQ04.14)
- Хувилгааны суурь их тэнгэр (TMQ 04.15)
- Жадэ адын өвчин (TMQ04.16)

#### **Долоодугаар тойролт: Яаралтай тусламж**

- Яаралтай тусламжийн суурь зарчим, эрэмбэлэх, шалтгаан, эмгэг жамыг тогтоож, эмнэл зүйн шинжийг үндэслэн оношлох;
- Яаралтай тусламжид өргөн хэрэглэдэг эм, эмчилгээний зарчмыг мэдэх, зөв цэгцтэй, яаралтай тусламж үзүүлэх аргуудыг эзэмших;
- Амь тэнссэн үед амьсгал удирдах, тусламж үзүүлэх;
- Зүрхний шигдээс, гипертензийн криз, амьсгалын дутагдал, хордлогыг оношлох, цус алдалтыг тогтоох, хүчил, шүлтийн тэнцвэр алдагдлыг зохицуулах
- Гаднын шалтгаантай гэмтлийн үед шаардлагатай тусламж үзүүлэх

#### **Ажлын байрны сургалт (On-the-Job Training)**

Аргачлал	Суралцагч эмчийн тоо	Үргэлжлэх цаг, давтамж	Сургалт явагдах газар	Үйлчлүүлэгч/ Хэрэглэгдэхүүн	Удирдагч хамтрагч
Амбулаторийн үзлэг хийх	1	3 цаг 7 хоногт 2 удаа	Амбулатори	Өвчтөн	Эмнэл зүйн сургагч багш
Хяналтын тойрон үзлэг хийх	3-5	1 цаг Өдөр бүр	Тасаг	Өвчтөн	Эмнэл зүйн сургагч багш
Сургалтын тойрон хийх үзлэг	3-5	1 цаг 7 хоногт 1 удаа	Сургалтын өрөө, танхим	Слайд	Эмнэл зүйн сургагч багш
Жирэмсэн, төрсний дараах хяналт зөвлөгөө өгөх	1	Хяналтад байгаа жирэмсэн эх, төрсөн эх	Амбулатори, гэрээр	Жирэмсэн эх, төрсөн эх	Эмнэл зүйн сургагч багш
Төрөлт					Эмнэл

удирдахад оролцох	1	Тохиолдол байгаа үед	Төрөх өрөө	Өвчтөн	зүйн сургагч багш
Нярайн үзлэг хийх, зөвлөгөө өгөх	1	Хяналтад байгаа нярай	Амбулатори, гэрээр	Нярай	Эмнэл зүйн сургагч багш
Гардан хийх үйлдэл	1	3 цаг 7 хоногт 2 удаа	Амбулатори, Tасаг	Өвчтөн	Эмнэл зүйн сургагч багш

#### **Хяналтын тойрон үзлэг:**

Суралцагч-эмч нь хэвтэн эмчлүүлж байгаа өвчтөний биеийн байдлын талаар эмнэлзүйн сургагч-багшид (бусад эмч) танилцуулах зорилготой үзлэг хийнэ.

Үүний тулд суралцагч-эмч нь урьдчилан бие даан өвчний түүх, сувилагчийн тэмдэглэлийг үзэж танилцсан, өвчтөнтэй уулзаж асуумж цуглуулж (ганцаарчилсан үзлэг), эмнэл зүйн сургагч-багшид (бусад эмч) танилцуулахад бэлдэнэ. Танилцуулга хийхдээ хувь хүний мэдээллийг анхаарна. Танилцуулгыг сургалтын өрөө, танхим эсвэл өвчтөний өрөөнөөс гадна хийх ба өвчтөний орны дэргэдэх тойрон үзлэгийг эмнэл зүйн сургагч-багштай (бусад эмч) хамт хийнэ. Хяналтын тойрон үзлэгээр өвчтөнөөс асуумж авах, үзлэг хийх аргад суралцана.

#### **Сургалтын тойрон үзлэг:**

Сургалтад тохиромжтой 1-2 өвчтөнийг сонгож, өвчтөний биеийн байдлыг суралцагч-эмч нь танилцуулах ба бусад оролцогчид (хамтран суралцагч эмч, эмнэл зүйн сургагч-багш, бусад эмч) асуулт тавьж, хэлэлцүүлэг хийнэ.

Эмнэл зүйн 1 тохиолдолд 30-60 минут зарцуулна. Үүний дараа өвчтөний орны дэргэд үзлэг хийнэ. Хэлэлцүүлгийн явцад эмнэл зүйн таамаглал дэвшүүлэх, онош тавих зэрэгт суралцана.

#### **Гардан үйлдэл хийх:**

Сургалтад тохиромжтой 1- 2 өвчтөнийг сонгож, суралцагч эмч нь эмнэл зүйн сургагч-багш, бусад эмчийн удирдлага дор эмчилгээг гардан хийнэ. 1 өвчтөнд 30-60 минут зарцуулна. Эмчилгээний явцад эмнэл зүйн шинж тэмдэг, эмчилгээний зарчим, хийх арга зэрэгт суралцана.

**Танхимын сургалт (Off-the Job Training)**

Аргачлал	Суралцагч эмчийн тоо	Үргэлжлэх цаг, давтамж	Сургалт явагдах газар	Хэрэглэгдэхүүн	Удирдагч, хамтрагч
Бие даалт	1	Тохиромжтой, чөлөөт цаг	Гэртээ, номын сан	Ном, интернэт	Өөрөө, хамтран суралцагч эмч
Лекц	20 хүртэл	7 хоногт 2-3 удаа 1 цаг	Сургалтын анги, танхим	Слайд	Эмнэл зүйн сургагч багш, хамтран суралцагч эмч
Журнал клуб (ховор тохиолдол)	20 хүртэл	7 хоногт 1 удаа 1 цаг	Сургалтын анги, танхим	Слайд, эрдэм шинжилгээний өгүүлэл	Эмнэл зүйн сургагч багш, хамтран суралцагч эмч
Өглөөний хэлэлцүүлэг	20 хүртэл	7 хоногт 1 удаа 1 цаг	Сургалтын анги, танхим	Слайд, эрдэм шинжилгээний өгүүлэл, хэвлэл мэдээллийн нийтлэл, сошиал платформ	Эмнэл зүйн сургагч багш, хамтран суралцагч эмч
Симуляци (дуураймал орчин)	5 хүртэл	7 хоногт 1 удаа 1 цаг	Яаралтай тусламжийн өрөө	Хамтран суралцагч эмч, манекин	Эмнэл зүйн сургагч багш

**Үйл ажиллагааны хуваарь**

Цаг	Даваа	Мягмар	Лхагва	Пүрэв	Баасан
~8:00-9:00	Ганцаарчилсан үзлэг /Өдөр бүр/ Өглөөний хэлэлцүүлэг /тохиромжтой цаг, өдөр/				
9:00-10:00	Хяналтын тойрон үзлэг /Өдөр бүр/				
10:00-12:00	Амбулаторийн үзлэг	Бие даалт	Амбулаторийн үзлэг	Бие даалт	Амбулаторийн үзлэг
12:00-13:00	Бие даалт	Лекц, семинар	Бие даалт	Лекц, семинар	Журнал клуб
16:00-17:00	Сургалтын тойрон үзлэг	Бие даалт	Сургалтын тойрон үзлэг	Бие даалт	Бие даалт

## **ДОЛОО. ҮНЭЛГЭЭ, ЭРГЭН ЗӨВЛӨГӨӨ**

### **7.1. Суралцагч эмч ба хариуцагч**

Сургалтын 2 жилийн хугацаанд суралцагч-эмч хэрхэн ахин дэвшиж байгаа, юуг сайжруулах тухай зөвлөгөө өгөх, суралцагч-эмчийн хувийн төлөвлөгөөний (*career plan*) талаар зөвлөлдөх, тэднийг хариуцан ажиллах хүн (*mentor*) цаашид “хариуцагч” гэх)-ийг хуваарилна. Суралцагч эмч нь сургалт эхлэх үед хариуцагчтай уулзах ба цаашид 2-3 сар тутамд 1 удаа уулзаж ярилцан, үнэлгээтэй танилцаж, зөвлөгөө авна.

### **7.2. Суралцагч эмч ба эмнэл зүйн сургагч багш**

Суралцагч эмчийн тойролт бүрд сургалт удирдах эмнэл зүйн сургагч багшийг хуваарилна:

- Суралцагч эмч нь тухайн тойролт эхлэхээс өмнө эмнэл зүйн сургагч багштай уулзаж, тойролтын хугацаанд тавьсан зорилтоо ярилцана.
- Суралцагч эмч нь тойролтын явцад тавьсан зорилтод хүрэхийн тулд дутагдаж байгаа зүйл, түүнийг нөхөхөд хэрэгцээтэй байгаа зүйлийн тухай эмнэл зүйн сургагч багштай ярилцана.
- Суралцагч эмч нь тойролт дуусахад эмнэл зүйн сургагч багштай ярилцлага хийж, сургалттай холбоотой асуудлаар заавар, зөвлөгөө авна.

### **7.3. Үнэлгээний арга**

#### **7.3.1. Төгсөлтийн шалгалт**

“Уламжлалт анаа ухааны хүүхэд судлал”-ын үндсэн мэргэшлийн сургалтын төгсөлтийн шалгалт өгнө. Энэхүү төгсөлтийн шалгалтад тэнцсэн тохиолдолд суралцагч эмчид “Монголын уламжлалт анаа ухааны хүүхэд судлал” үндсэн мэргэшлийн эмчийн үнэмлэх олгоно.

#### **7.3.2. Сорилын шалгалтын үнэлгээ**

Тойролт бүрд үзсэн онолын мэдлэгийг тестээр шалгаж үнэлнэ. Сорил нь ганц зөв хариулттай, олон зөв хариулттай, харилцан хамаарлын, шалтгаан хамаарлын гэсэн 4 хэлбэртэй байна.

Сорилын шалгалт авах багшийг сургалтын албанаас томилно. Үнэлгээний дүнг суралцагч эмч болон хариуцагчид танилцуулж, үнэлгээнд үндэслэсэн хариуцагчаас суралцагчид зөвлөгөөг өгнө.

#### **7.3.3. Ажлын байранд суурилсан үнэлгээ (*Workplace-based Assessment*)**

##### **360 хэмийн үнэлгээ (360-Degree Assessment):**

Суралцагч эмчийн мэргэжлийн байх (*professionalism*) болон зохион байгуулагч (*organizer*), манлайлагч (*leader*) байх зэргийг үнэлэхэд хэрэглэнэ. Ажлын байранд суурилсан үнэлгээг 2 жилийн сургалтын дунд болон төгсөх үед хийнэ. Тойролтыг удирдсан эмнэл зүйн сургагч багш, сувилхуйн мэргэжилтэн, тухайн тасаг, нэгжийн хамтран ажилласан эмч, эмнэлгийн мэргэжилтэн, өвчтөн зэрэг нийт 5 хүн тус тусдаа үнэлнэ. Үнэлгээ хийх багийг сургалтын албанаас томилно.

Багийн гишүүдийн үнэлгээний дунджаар суралцагч-эмчийн нэгдсэн үнэлгээг гарган түүнд танилцуулж, үнэлгээнд үндэслэн эргэн зөвлөгөөг өгнө.

### **Mini-CEX/Эмнэл зүйн дасгал үнэлгээ (Mini-Clinical Evaluation Exercise):**

Зайлшгүй таньж мэдэх 60 шинж тэмдгээс тойролт бүрд 48-аас доошгүй шинж тэмдгийг тус бүр 3-аас доошгүй удаа буюу 144-өөс доошгүй удаа үнэлгээ хийнэ. Өөр тойролтод ижил шинж тэмдгээр үнэлгээ хийсэн ч болно.

Үнэлгээ хийх эмчийг эмнэл зүйн сургагч-багш эсвэл тухайн тасаг, нэгжийн туршлагатай эмч нараас суралцагч-эмч өөрөө сонгох ба тухайн сонгосон эмч шууд ажиглаж, үнэлгээ хийсний дараа үр дүнг суралцагч эмчид танилцуулж, цаашид хэрхэн сайжруулах зөвлөгөө өгнө.

### **Гардан үйлдлийн ур чадварын шууд ажиглалт/DOPS (Direct Observation of Procedural Skills):**

Зайлшгүй сурх 40 гардан үйлдлээс 32-аас доошгүйг хийж чаддаг болсныг эмнэл зүйн сургагч-багш нотолж, баталгаа өгөх хүртэл давтан үнэлгээ хийнэ.

Үнэлгээ хийх эмчийг эмнэл зүйн сургагч-багш эсвэл тухайн тасаг, нэгжийн туршлагатай эмч нараас суралцагч эмч өөрөө сонгох ба тухайн сонгосон эмч шууд ажиглаж, үнэлгээ хийсний дараа үр дүнг суралцагч-эмчид танилцуулж, цаашид хэрхэн сайжруулах талаар зөвлөгөө өгнө.

### **Портфолио үнэлгээ (Portfolio Assessment):**

Суралцагч-эмч нь сургалтын хугацаанд судалсан лекц, эмнэлгийн анхан шатны тусламж үйлчилгээний сургалтын үеэр эрүүл мэндийн сургалт, сурталчилгаа хийсэн материал зэрэг сургалттай холбоотой бусад бичиг баримтыг үр дүн болгож хадгална.

#### **7.4. Үнэлгээний дүнг хянах**

- 360-хэмийн үнэлгээний дүнг сургалтын алба хяналт тавьж, хадгална.  
Үнэлгээний дүнг суралцагч-эмч, хариуцагчид танилцуулах ба бусадтай хуваалцахгүй байхыг анхааруулна.
- Mini-CEX болон DOPS үнэлгээний дүнг суралцагч-эмч өөрөө хадгална.
- Портфолиод үнэлгээ, эмнэл зүйн сургагч-багштай зөвлөлдсөн асуудал, өгсөн зөвлөгөөг бичиж тэмдэглэн хадгална.
- Суралцагч эмч нь тойролт бүрийн төгсгөлд Mini-CEX болон DOPS үнэлгээний дүнг сургалтын албанад хүлээлгэн өгнө.
- Сургалтын алба үнэлгээний дүнг сургалтын хяналтын зөвлөлд танилцуулах ба сургалтын төгсгөлд хариуцагчаас суралцагч-эмчид зөвлөгөө өгнө.

#### **7.5. Сургалтын төгсөлтийг шийдвэрлэх**

- Тойролт бүрд хийгдсэн Mini-CEX болон DOPS үнэлгээний дүнг нэгтгэсний үндсэн дээр суралцагч-эмчийг тухайн тойролтыг төгсгөх эсэх шийдвэрийг сургалтын хяналтын зөвлөл гаргана. Сургалтын хяналтын зөвлөл нь тойролт бүрд хийгдсэн Mini-CEX болон DOPS үнэлгээний

дүн, 360 хэмийн үнэлгээний нэгдсэн дүн, суралцагчийн сургалтын ирц, зайлшгүй таньж мэдэж суралцах шинж тэмдэг, өвчний тохиолдол, гардан үйлдлийн тоог харгалзан сургалтын төгсөлтийн эцсийн шийдвэрийг гаргана. Шийдвэр гаргах шалгуур нь:

- Зайлшгүй сургалтад оролцсон байх өдрийн тоо буюу сургалтын ирц: Хөдөлмөрийн тухай хуульд заасан цалинтай амралтын өдрийн тоо, хүндэтгэх шалтгаантай болон амралтын өдрийн тоог ирцэд хамааруулна. Амралтын өдрийн тоо нь сургалтын тойролт тус бүрийн нийт өдрийн 20%-аас хэтрэхгүй байна. Сургалтын ирц хангалтгүй бол тухайн тасарсан сургалтын өдөр, агуулгыг нөхүүлнэ.
- Зайлшгүй таньж мэдэх шаардлагатай 60 шинж тэмдгээс 2 жилийн турш 48-аас доошгүйг оношилж, эмчлэн туршлага хуримтлуулсан байна. Зайлшгүй туршлага хуримтлуулсан байх шаардлагатай өвчний тохиолдлын тоо нь:
  - \* Тойролт бүрд заагдсан өвчний бүх тохиолдлыг тус бүр 3-аас доошгүй удаа үзэж, туршлага хуримтлуулсан байна.
  - \* Зайлшгүй суралцах 40 гардан үйлдлээс 2 жилийн турш 32-оос доошгүйг хийж гүйцэтгэн, туршлага хуримтлуулсан байна.
- Тойролт бүрийн төгсгөлд эсвэл 2 жилийн сургалтын эцэст суралцагчийг төгсгөх боломжгүй гэсэн шийдвэр гарсан тохиолдолд шалтгаан, цаашид сургалтыг хэрхэн үргэлжлүүлэх тухай шийдвэр, зөвлөмжийг сургалтын алба болон хариуцагчаас тухайн суралцагч эмчид тайлбарлаж өгнэ

## НАЙМ. ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖҮҮЛЭЛТ

### 8.1. Сургалтын хяналтын зөвлөл

- Хяналтын зөвлөл нь сургалтын албаны мэргэжилтэн, эмнэлгийн тусlamж, үйлчилгээний байгууллагын дэд дарга, тухайн тойролтын сургалт хариуцагч, сувилахуйн албаны, эмнэлгийн захиргааны албаны, суралцагч эмчийн төлөөллөөс тус тус бүрдэнэ. Сургалтын хяналтын зөвлөл нь эмнэлгийн тусlamж, үйлчилгээний байгууллагын даргын шууд удирдлагад ажиллана.
- Сургалтын хяналтын зөвлөл улиралд нэг удаа хуралдана.
- Сургалтын хяналтын зөвлөл нь суралцагч-эмчийн сургалт, тулгарсан асуудалтай танилцах, суралцагч-эмчтэй холбоотой бүх асуудлыг ярилцаж, шийдвэрлэх арга замыг тодорхойлно.
- Сургалтын хяналтын зөвлөлийн гишүүд сургалтыг илүү сайжруулахын тулд өөрийн мэдлэг, боловсролоо дээшлүүлэхийг зорьж ажиллана.

### 8.2. Хөтөлбөрийн хяналт

- Сургалтын алба хөтөлбөрт улирал бүр хяналт тавина.
- Энэхүү хөтөлбөрийг 5 жил тутамд үнэлнэ.
- Хөтөлбөр хэрэгжүүлэхэд шаардлагатай сургалтын төлөвлөгөө гаргах, эмнэл зүйн сургагч-багшид чиглэсэн сургалт (*Faculty Development*), суралцагч-эмчийн нийгмийн асуудалд дэмжлэг үзүүлэх, шаардагдах санхүүжилтийг төсөвт тусгах зэргийг сургалтын алба хариуцна.

- Хөтөлбөрт нэмэлт, өөрчлөлт хийх шаардлагатай тохиолдолд сургалтын хяналтын зөвлөлөөр хэлэлцүүлэн, өөрчлөлт оруулна. Энэ тухай Эрүүл мэндийн хөгжлийн төвд албан бичгээр ажлын 10 хоногт багтаан мэдэгдэнэ.

### 8.3. Сургалтын танилцуулга (*Orientation*)

Сургалт эхлэхийн өмнө тойролт бүрийн сургалтын төлөвлөгөө (*Training plan*) болон хөтөлбөрийн (*Curriculum*) агуулгын уялдааг тодорхой ойлгох, сургалт эрхлэх байгууллага (эмнэлэг, эрүүл мэндийн төв), түүний үйл ажиллагаа, эмчилгээ, оношилгооны аюулгүй байдал, халдварт хамгааллын тухай суралцагч-эмчид тодорхой ойлголт өгөх зорилго бүхий танилцуулга хичээлийг зохион байгуулна.

## 360 ХЭМИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС

Суралцагч-эмчийн

Үнэлгээ хийгч:  Эмнэл зүйн сургагч-багш  Сувилагч  Бусад

Суралцагч-эмчийг ажигласны үндсэн дээр, бусдаас сонссон, мэдсэн зүйл дээр бус, түүний зан үйлийг хэр давтамжтай байсныг өөрийн ажигласнаар оноог тавина уу.

<input type="checkbox"/> NA	<input type="checkbox"/> 1	<input type="checkbox"/> 2	<input type="checkbox"/> 3		<input type="checkbox"/> 4	
Үнэлэх боломжгүй	Ховор (£19%)	Заримдаа (20-49%)	Ихэнхдээ (50-79%)		Бараг бүгд (>80%)	
Өвчтөний гэр бүлийн хувийн асуудлыг хүндэтгэн үздэг.	<input type="checkbox"/> NA	<input type="checkbox"/> 1	<input type="checkbox"/> 2	<input type="checkbox"/> 3	<input type="checkbox"/> 4	
Эмнэлгийн бичиг баримтыг бүрэн гүйцэд, алдаагүй, хугацаанд нь хөтөлдөг.	<input type="checkbox"/> NA	<input type="checkbox"/> 1	<input type="checkbox"/> 2	<input type="checkbox"/> 3	<input type="checkbox"/> 4	
Эмнэлзүйн амын эрүүл мэндийн асуудалд өөрийн санаачилгаар хувь нэмрээ оруулдаг.	<input type="checkbox"/> NA	<input type="checkbox"/> 1	<input type="checkbox"/> 2	<input type="checkbox"/> 3	<input type="checkbox"/> 4	
Үйлчлүүлэгчийн өвчинд тохирсон эмчилгээний арга, технологийг сонгох чадвар	<input type="checkbox"/> NA	<input type="checkbox"/> 1	<input type="checkbox"/> 2	<input type="checkbox"/> 3	<input type="checkbox"/> 4	
Хувь хүний онцлогийг харгалзан өвчтөнийг хүндэтгэн эмчилдэг.	<input type="checkbox"/> NA	<input type="checkbox"/> 1	<input type="checkbox"/> 2	<input type="checkbox"/> 3	<input type="checkbox"/> 4	
Өөрийн мэргэжлийн онол, аргазүйн мэдлэгээ дээшлүүлэхийн тулд бусад боломжийг ашигладаг.	<input type="checkbox"/> NA	<input type="checkbox"/> 1	<input type="checkbox"/> 2	<input type="checkbox"/> 3	<input type="checkbox"/> 4	
Өөрийн анагаах ухааны онолын мэдлэг, чадвараа дээшлүүлэхэд бие даан суралцдаг арга барил	<input type="checkbox"/> NA	<input type="checkbox"/> 1	<input type="checkbox"/> 2	<input type="checkbox"/> 3	<input type="checkbox"/> 4	
Эмнэл зүйн талбарт бусад эмнэлгийн эмч, мэргэжилтэнтэй хамтран ажиллах арга барилд хэрхэн суралцсан	<input type="checkbox"/> NA	<input type="checkbox"/> 1	<input type="checkbox"/> 2	<input type="checkbox"/> 3	<input type="checkbox"/> 4	
Эмнэл зүйн талбарт эрүүл мэндийн тусlamж, үйлчилгээнд зохион байгуулах, манлайлах чадвар	<input type="checkbox"/> NA	<input type="checkbox"/> 1	<input type="checkbox"/> 2	<input type="checkbox"/> 3	<input type="checkbox"/> 4	
Эмнэлгийн үйл ажиллагааг төлөвлөх, хэрэгжүүлэх, биелэлт, үр дүнг дүгнэх, тайлагнах чадвар	<input type="checkbox"/> NA	<input type="checkbox"/> 1	<input type="checkbox"/> 2	<input type="checkbox"/> 3	<input type="checkbox"/> 4	

1 эсвэл 4 оноо тавьсан бол тухайн асуултын дагуу саналаа бичнэ үү.

**Дүгнэлтийг тодорхой бичих хэрэгтэй.** Жишээ нь: "Тэр бол найдваргүй" гэх нь тодорхой биш. Илүү хэрэг болох дүгнэлт бол: "Тэр сүүлийн 3 удаагийн журнал клубийн 2-т нь хэн нэгэнд урьдчилан мэдэгдэгдэлгүйгээр оролцсонгүй."

Өөрөөсөө асуу: Миний дүгнэлт цаашид сайжрахад нь суралцагч-эмчид хэрэг болох уу?

## ЭМНЭЛЗҮЙН ДАСГАЛ /MINI-SEX/ ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС

Он, сар, өдөр: / /

Суралцагч эмчийн нэр: \_\_\_\_\_ Үнэлгэчийн нэр:

Сургалт эрхлэх байгууллага: \_\_\_\_\_ Нэгж: \_\_\_\_\_ Газар:  Клиник  
 Тасаг  ЯТТ

Бусад \_\_\_\_\_ Өвчтөний нас: \_\_\_\_\_ Өвчтөний хүйс:  Эр  Эм  
 Өвчтөний зовуурь:  Уйлах шинж /үргэлжид удаан уйлах, чанга уйлах, шөнө уйлах, үүрээр уйлах, бүрийн цагт уйлах, нарийн сөөнгө дуугаар уйлах, ихсэж багасаж тасалдан зогсох байдалтай уйлах, чанга дуу чимээ тэсвэрлэхгүй уйлах/  Өвдөх шинж /алин өвдсөн хэсгээ барих, барьсан хэсэгт дарвал тэсэхгүй өвдөх, үүрийн цагт өвдөх/  Шээсний шинж /шээс чавдагших, шээс дахин дахин цувирах, шээсний төгсгөлд гэнэт хаагдах, шээсний дунд махны нитгэл гарах/  Амьсгалын шинж /богино амьсгалах, урт амьсгалах, амьсгаадах, цээж хонхолзох, хяхтнаж амьсгалах, хэржигнэх/  Нүүрний шинж /нүүр харлах, нүүр шарлах, нүүр тослог болох/  Нүдний шинж /нүд шарлах, нүд хөхрөх, нүд улайх, нүд цайх, нүдний харц дээш гөлийх, нүдээ нээхэд бэрх болох, нүд ширгэх, нүд халуун оргих, нүдээ олон анивчих, нүдний булангаараа харах, нүд хавдах, нүдээрээ тэнгэр ширтэх/  Хэлний шинж /хэл богиносох, хэл голоороо шарлах, хэл цайрах, хэлээ хөхөж хоосноор зажлах, хэл мурийх/  Чихний шинж /чихний судас харлаж бүдүүрэх, чихний ар талд шарлах, чихнээс өгөр цувирах, чих дүлийрэх, чих толгойд наалдах/  Хумсны шинж /хумс хурц болох, хумс харлах, хумс уртсах/  Хүйн шинж /хүй овойх, хүй борлох, хүй хавдах, хүй толь мэт хатуу болох, хүй өгөрлөж хонхойх/  Эхийн хөхний сүүний шинж / хөхний сүү шарлах, хөхний сүү иsgэлэн болох, хөхний сүүг усанд дусаахад хөөстэй хөвөх, хөхөвтөр живэх, хэсэгчлэн тасрах/  Дууны өнгө /дууны өнгө нь сул болох, дууны өнгө нь ишигний дуу адил болох/  Арьсны өнгө /арьсны өнгө хөхрөх, арьсны өнгө шарлах, арьсны өнгө алт адил шарлах, хувхай цайх, 4-н толио шарлах, 4-н толио цагаан гялтар болох, 4-н толио улаан болох/  Өтгөний шинж /өтгөн хаагдах, өтгөний хэмжээ нь ихсэх/  Бөөлжих /цустай бөөлжих, шараар бөөлжих, ууж, хөхсөний дараа бөөлжих, юу идсэнээрээ бөөлжих, хөөс бадган салстай бөөлжих, хоосноор огиулах/  Суулгах /хөхний сүү адил суулгах, улаан өнгөтэй суулгах, шар өнгөтэй суулгах, ногоон өнгөтэй суулгах, хөхөвтөр өнгөтэй суулгах, утааны шүүс адил суулгах, идсэн идээний өнгөөр суулгах, цайвар, хөөстэй суулгах, дуу ихтэй суулгах, шар мөөгний зутан адил суулгах/  Ханиах /хий ханиах, цэرتэй ханиах, ам нүүрээ хумъж ханиах, олон ханиах, угсрулан ханиах/  Хавдах /өвчүү хэсэгт хавдах, цээжин бие хавдах, нүд хавдах, уруул хавдах/  Хатах /ам хатах, хэл хатах, хамрын үүд хатах/  Хаг тогтох /амд хаг тогтох, хэлэн дээр хаг тогтох, уруулд хаг тогтох, шүдэнд хаг тогтох, буйланда хаг тогтох, хамарт хяруу адил цагаан хаг тогтох/  Самардах /цээжин биеэ самардах, эхийгээ самардах, газар самардах/  Эвшээж шинж /эвшээж чадахгүй, их эвшээх/  Гөвдрүү гарах /цагаан гөвдрүү гарах, гөвдрүү тагнайд

гараах/ □ Зулай лугших □ Дуршил нь хаагдах □ Инээж тоглохгүй болох □ Их хөлпрөх □ Хөхөө хөхөхгүй болох □ Толгой, цээжин бие гадагш гараах, дагз гэдийх □ Өсгийгөөрөө гишгэж чадахгүй болох □ Их сарвалзах, таталт өгөх, чичрэх □ Шилэн хүзүү хөших □ Цээжин бие хөших □ Яраглах □ Зүрх дэлсэх □ Гараа хөхөх □ Гэдэс олгой хоржигнох, дүүрэх. Унжих □ Ундууцах □ Шар үс нь буцах, босох □ Ундаасах □ Ам хамраа 2 гараараа дарах □ Хөл, гараа хумиад тэнийлгэж чадахгүй болох □ Нударгаа зангидах □ Давсаг, шээсний сүв эвэршээж өвдөх □ Толгой хавдах □ Хоолой хаагдах □ Шүлс нь ихсэх □ Нулимс цувирах /нэг нүднээс цувирах/ □ Эхийн хөх, өөрийнхөө хэлийг шүдээрээ зуух Шүдээ хавирах □ Турах □ Бөгсний судас хавдах □ Толгойгоо цохих, дохих □ Зогьсох □ Гараараа хошногоо ухах, базах □ Тагнайгаа таших □ Цочиж, эмээх □ Хэвлэйн судас харлаж тодрох □ Ам нь мурийх □ Үс нь сэгсийх

Сайн талууд	Сайжруулахад чиглэсэн зөвлөгөө	Бусад санал

Сургалтын хугацаанд суралцагч-эмчийн ямар түвшинд байгааг ажигласнаар үнэлнэ үү. <b>Бодит үзлэг хийх шаардлагагүй тохиолдолд тэмдэглэнэ үү.</b>			
Үнэлгээ	Хангалтгүй	Завсрын	Хангалттай
Өвчний түүх бүрдүүлэлт			
Бодит үзлэг			
Оношилгоо, эмчилгээний менежмент			
Эмчийн харилцаа, ёс зүйн ур чадвар			
Эмнэлзүйн ерөнхий ур чадвар			

<b>Сайжруулахын тулд зөвшилцэж биелүүлэх үйлдэл</b>

Үнэлэгчийн гарын үсэг \_\_\_\_\_ Суралцагч эмчийн гарын үсэг  
\_\_\_\_\_

“Хангалттай” гэж тодорхойлоход хэрэглэгдэх үзүүлэлт	
Өвчний түүх	<ul style="list-style-type: none"> <li>Ялган оношилгоо хийхүйц дэлгэрэнгүй асуумж авдаг.</li> <li>Өвчтөний хэрэгцээг илрүүлж, хариу үзүүлдэг.</li> <li>Өвчтөний дохио, зангааг ойлгож, тохиромжтой хариу үзүүлдэг.</li> </ul>
Бодит үзлэг	<ul style="list-style-type: none"> <li>Ялган оношилгоо хийхүйц дэс дараалсан бодит үзлэг хийдэг</li> <li>Үзлэгийн үед өвчтөнд таатай байдал төрүүлдэг</li> </ul>
Эмнэл зүйн менежмент	<ul style="list-style-type: none"> <li>Өвчнийг зөв оношилдог</li> <li>Оношилгоо, эмчилгээнд шаардлагатай шинжилгээг төлөвлөж, үр дүнг ашигладаг.</li> <li>Тохирсон эмчилгээг хийдэг.</li> <li>Тохирсон тасаг, эмнэлэгт шилжүүлдэг, цааш нь хяналт тавьдаг.</li> </ul>
Харилцааны ур чадвар	<ul style="list-style-type: none"> <li>Өвчтөн, түүний гэр бүл, асран хамгаалагч, төрөл, садны хүмүүстэй эелдэг харьцдаг.</li> <li>Өвчтөн, түүний гэр бүл, асран хамгаалагч, төрөл, садны хүний зовнилыг хуваалцаж, хүндэтгэлтэй ханддаг.</li> <li>Өвчтөн, түүний гэр бүл, асран хамгаалагч, төрөл, садны хүнтэй эелдэг, энгийн үг хэллэг хэрэглэж харилцдаг.</li> </ul>
Эмнэл зүйн ерөнхий чадвар	<ul style="list-style-type: none"> <li>Системтэй (харилцан уялдаатай) арга замыг тодорхойлдог.</li> <li>Өвчтөний таатай, аюулгүй байдлыг хангахад анхаарал хандуулдаг.</li> <li>Өвчтөн гэр бүлийнхээ хэн нэгнийг энэ эмчээр эмчлүүлэхийг зөвшөөрөх сэтгэгдэл төрүүлэх чадвар</li> </ul>

### Хавсралт 3

#### **ГАРДАН ҮЙЛДЭЛ /DOPS/-ИЙН ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС**

Он, сар, өдөр / /

Суралцагч-эмчийн нэр: \_\_\_\_\_ Үнэлгэгчийн нэр: \_\_\_\_\_

Сургалт эрхлэх байгууллага: \_\_\_\_\_ Нэгж \_\_\_\_\_ Газар:  Клиник  Тасаг  
 ЯТТ

Гардан үйлдэл:  Судсаар оношлох /чихний судсаар оношлох, бугуйн судсаар оношлох, хурууны судсаар оношлох, чамархайн судсаар оношлох/  Шээсээр оношлох  Хэлээр оношлох  Эхийн сүүгээр оношлох  Жирэмсний үеийн бария хийх  Бүтэн биеийн зөөлөн бария хийх  Хэсэгчилсэн бария хийх (Толгойн бария хийх, нурууны бария хийх, тухайн үе мөчдөд бария хийх, 4-н толион бария хий)  Арвайтай бария хийх  Халуун тосон бария хийх  Цэгэн бария хийх  Рашаанд оруулах  Ясны шөлөнд оруулах  Дэвтээлэг /ороох дэвтээлэг хийх, ууран дэвтээлэг хийх/  Туулгах  Хануур засал /зэтрээс цус авах, шивүүр хийх, самнуур хийх/  Хийх  Төөнө (эсгий төөнө хийх, утаат төөнө хийх, эмт төөнө хийх)  Жин (халуун жин тавих, хүйтэн жин тавих) тавих  Угаалга хийх  Түрхлэг түрхэх  Нирхагаар татах  Зөөлөн шимт хийх  Зөгийн балтай татлага хийх  Бумба тавих  Шавар тавих  Зүү тавих  Гаргалга хийх /цагаан гаргалга хийх, улаан гаргалга хийх, исгэлэн гаргалга хийх, сармисан гаргалга хийх/  Усаар шавших  Соруул засал хийх  Дусаалга /нүдний дусаалга дусаах, чихний дусаалга дусаах/  Утлага хийх  Шарлага хийх  Сэхээн амьдруулалтын хүүдий, маск сонгох, шалгах, хэрэглэх  Хиймэл амьсгал хийх ба амьсгалын аппарат хэрэглэж амьсгал удирдах  Ларингоскоп ашиглан гуурсан хоолойд интубацийн гуурс байрлуулах, шалгах  Зүрхэнд иллэг хийх  Дефибрилятор ашиглах  Ил далд цус алдалтын үед яаралтай тусламж үзүүлэх  Нүд, чих, хамар хоолойд орсон гаднын биетийг авах  Амьтанд хазуулах, могой шавьжанд хатгуулсан хүний шарханд анхны цэгцлэлт хийх  Үений мултралыг оруулах, ясны хугарлын үед боолт хийх

Суралцагч эмчийн тухайн гардан үйлдлийг хийсэн тоо

Үнэлгээний үзүүлэлт	Хангалтгүй	Завсрыйн	Хангалттай	Ажиглагдаагүй /үнэлэх боломжгүй/
Хийх гэж буй үйлдлээ өвчтөнд тайлбарладаг, түүнээс зөвшөөрлийн хуудас авдаг.				
Гардан үйлдэл хийх бэлтгэлийг зохистой хангадаг.				
Халдвартгүйжүүлэх үйлдлийг гүйцэтгэдэг, багаж хэрэгслийг аюулгүй хэрэглэдэг.				
Гардан үйлдлийн арга				

барилыг чадвар.	гүйцэтгэх			
Өөрийн үйлдлийг шаардлагатай бусдаас тусlamж авдаг.	чадахгүй оилгож, үед			
Багаж материалын цэвэрлэгээ, халдвартгийг хангадаг.	хэрэгсэл,			
Шаардлагатай баримтыг бүрдүүлдэг.	бичиг гүйцэт			
Гардан үйлдэл хийх ерөнхий чадвар				

Зөвлөмж:

\* Сайн тал:

\* .....

\* Сайжруулах тал:

\* .....

Бусад санал:

.....

Үнэлэгчийн

гарын

Үсэг:

Суралцагч эмчийн гарын үсэг: \_\_\_\_\_

## **НОМ СУРАХ БИЧИГ, ГАРЫН АВЛАГА**

1. Рашааны шим найман гишүүнт нууц увдисын үндэс
2. Бидэр-ОНбо
3. Манаглхантав
4. Мэбо шаллүн
5. Ганжуур сориг жэдүй
6. Данжуур сориг жэдүй
7. Жибасова
8. Монадсова
9. Монадсова, жибасова, доннадсова
- 10.Брумма проддэн дан жибанэржод горжи шэйжа
- 11.Жибажатавжи лаглэн
- 12.Годванбо надсова, жибасова, монадсова
- 13.Зандодсингтг данянтиг (42-р боть)
- 14.Манаг бодимарбо додмадча (63-р боть)
- 15.Манаглхантавжи синбрый, эммяннян мянданби салжэд, рэгсигнэүжалва  
(82-р боть)
- 16.Жамбалчойжи данзинпринлай манагринчэнжуннай
- 17.Д. Малчинхүү “Хүүхдийн өвчин”
- 18.С.С.Вялов “Хүүхдийн эрүүл мэндийн хэвийн үзүүлэлтийн лавлах”